



2018 оны 12 дугаар сарын 03
№45/1050/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Иргэний хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Амьтан, ургамал,
тэдгээрийн гаралтай түүхий эд,
бүтээгдэхүүнийг улсын хилээр
нэвтрүүлэх үеийн хорио цээрийн
хяналт, шалгалтын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Төрөөс мөнгөний бодлогын
талаар 2019 онд баримтлах
үндсэн чиглэл батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

398.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	1679
399.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1681
400.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1682
401.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1683
402.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1683
403.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1684
404.	Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1684

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

405.	Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 81	1685
406.	Б.Батзоригийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай	Дугаар 82	1685
407.	Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 13 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 83	1686



408.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 84	1686
409.	Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 85	1689
410.	Д.Хүрэлбаатарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалаас нь түдгэлзүүлэх тухай	Дугаар 86	1689
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
411.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 142	1690
412.	Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 144	1690
413.	Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгч болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 145	1691
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ			
414.	Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 13	1691
415.	Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 14	1698

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах 176², 177¹, 178¹ дүгээр зүйл нэмсүгэй:

1/176² дугаар зүйл:

“176² дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах

176².1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 176.2-т заасан тогтоолыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.

176².2.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч энэ хуулийн 163.1, 173.1-д заасан журмын дагуу хэргийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Энэ хуулийн 176².1-д заасны дагуу гомдол гаргасан этгээдэд энэ хуулийн 57.1, 57.4-т заасан журам хамаарахгүй.

176².3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 174.1-д заасан хугацаанд Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд хэрэг шийдвэрлэсэн байдал, гомдлын болон хууль зөрчсөн үндэслэлийг тусгасан байна.

176².4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлгүй гэж үзвэл 30 хоногийн дотор гомдол гаргагчид бичгээр хариу өгнө.”

2/177¹ дүгээр зүйл:

“177¹ дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан

177¹.1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцсон шүүх бүрэлдэхүүний хоёр шүүгч тусгай санал гаргасан, эсхүл Улсын дээд



шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан бол хэргийг 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

177¹.2.Энэ хуулийн 177¹.1-д заасан тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан явуулах тухай шийдвэр гаргаж, хуралдааны товыг тогтооно.

177¹.3.Энэ хуулийн 177¹.1-д заасан хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч даргална.

177¹.4.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс гадна Иргэний хэргийн танхимын нийт шүүгчдийн дөрөвний гурваас доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдоно.”

3/178¹ дүгээр зүйл:

“178¹ дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр

178¹.1.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 176².3-т заасны дагуу Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэргийг олонхын саналаар шийдвэрлэнэ.

178¹.2.Энэ хуулийн 178¹.1-д заасан шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл дүгнэлтийг хүлээн аваагүйд тооцно.

178¹.3.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

178¹.3.1.шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, энэ хуулийн 176².3-т заасан дүгнэлтийг хангахгүй орхих;

178¹.3.2.шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

178¹.3.3.магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

178¹.3.4.тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, магадлал, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;



178¹.3.5.шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;

178¹.3.6.шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд буцаах.

178¹.4.Энэ хуулийн 178¹.3-т заасан тогтоол танилцуулан сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.

178¹.5.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байна.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.2.7 дахь заалт нэмсүгэй:

“27.2.7.төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.”

2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 27.6 дахь хэсгийн “27.1.1, 27.1.5-д” гэснийг “27.1.1-д” гэж, 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно.” гэснийг “Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгоно.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “улсын мэргэжлийн” гэсний өмнө “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “Засгийн газарт оруулах” гэсний өмнө “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“26.4.Эрсдэлийн задлан шинжилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас томилогдсон мэргэжлийн баг гүйцэтгэнэ.”

3 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах” гэснийг “Малын генетик нөөцийн тухай”⁵, Мал, амьтны эрүүл мэндийн тухай⁶ гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “хөврөл үр” гэснийг “хөврөл” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “хөврөл үр” гэснийг “хөврөл, малын бусад үржүүлгийн бүтээгдэхүүн” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “Малын эрүүл мэндийн олон улсын байгууллагаас тогтоосон “А” жагсаалтын өвчин /цаашид “амьтны гоц халдварт өвчин” гэх/” гэснийг “мал, амьтны гоц халдварт өвчин /цаашид “амьтны гоц халдварт өвчин” гэх/” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

⁵Малын генетик нөөцийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁶Мал, амьтны эрүүл мэндийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “чанарын” гэсний дараа “болон мал эмнэлгийн, лабораторийн магадлан шинжилгээний” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.2.стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ авсан бараа, түүхий эдийг арилжих;”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах” гэснийг “Малын генетик нөөцийн тухай⁴, Мал, амьтны эрүүл мэндийн тухай⁵” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай” гэснийг “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

⁴Малын генетик нөөцийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁵Мал, амьтны эрүүл мэндийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 2 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд хүний эмийн асуудал хариуцсан зөвлөл, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд малын эмийн асуудал хариуцсан зөвлөл ажиллана.”

2 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах” гэснийг “Малын генетик нөөцийн тухай³, Мал, амьтны эрүүл мэндийн тухай⁴” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.2.Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна.”

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

³Малын генетик нөөцийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁴Мал, амьтны эрүүл мэндийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 2 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Батжаргалын Батзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

Б.Батзоригийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Батжаргалын Батзоригийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот**Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
13 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****М.ЭНХБОЛД****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2018 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд
баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд даалгасугай:

1/Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын



байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

2/гадаад валютын нөөцийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан түвшинд дунд хугацаанд хүргэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3/зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;
4/чанаргүй активыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;

5/санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжилтийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

6/санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах;

7/Монгол Улсын гадаад валютын урсгалын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улирал тутам тайлагнаж байх;

8/ипотекийн зээлийг эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдуулж урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх;

9/алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Дамба-Очир/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2018 оны
84 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлого нь эдийн засгийн болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг хөтөлөхөд чиглэгдэнэ.

1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1.Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2019-2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

1.2.Эдийн засгийн дархлааг дэмжих, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.3.Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.4.Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, бодлогын үр нөлөөг дээшлүүлнэ.

2.Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1.Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

2.2.Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3.Олон улсад мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.4.Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тогтолцоог сайжруулна.

3.Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх ажлын хүрээнд:

3.1.Үндэсний төлбөрийн системийн найдвартай ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох ажлыг үргэлжлүүлнэ.

3.2.Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

3.3.Олон улсад мөрдөгдөж байгаа тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

3.4.Банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, шинэ ололтыг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Д.Хүрэлбаатарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалаас нь түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Доржсүрэнхорлоогийн Хүрэлбаатарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалаас нь түдгэлзүүлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Гомбосүрэнгийн Буяннэмэхийг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, хүсэлт гаргасан Базарсадын Нацагдоржийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

**Шүүгч, ерөнхий шүүгчийн албан
тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Батмөнхийн Болор-Эрдэнийг Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгч болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дашгайн Отгончулууныг Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Батмөнхийн Болор-Эрдэнийг Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Д.Солонго /илтгэгч/, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Жадамба болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.



Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Жадамба Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд тус зүйлийн 3 дахь заалтад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхийг хуульчлан баталгаажуулсан байна. Өмчлөгч нь өөрийн материаллаг болон материаллаг бус хөрөнгөө өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах /өв залгамжлуулах/ бөгөөд аливаа хууль бус халдлагаас хамгаалах эрхтэй. ...

Харин Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна.

Иргэний хуульд зааснаар өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөх бөгөөд өвлөгч нь өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээдэг. Өв нээгдсэн газрын нотариатч өвлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн хуульд заасан журмын дагуу өвлөх эрхийн гэрчилгээ олгодог. Гэтэл тухайн өвлөгдөх эд хөрөнгө нь барьцаанд байгаа тохиолдолд гагцхүү барьцаалагч зөвшөөрсөн нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг олгохоор байна. Өөрөөр хэлбэл, барьцаалагч татгалзсан тохиолдолд иргэн Үндсэн хуульд заасан хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байна.

Иймд Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн эсэхийг магадлан шалгаж, хэрэв Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн бол хүчингүй болгож өгнө үү.” гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Хоёр. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад зааснаар Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй бөгөөд иргэний өв залгамжлуулах эрхийг хангах харилцааг Иргэний хууль, Нотариатын тухай хууль, нотариатын үйлдэл хийх заавар болон бусад холбогдох хууль, хуульчилсан актаар зохицуулсан байдаг.

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх үндсэн эрх, түүний хувийн эрх зүйн харилцаанд хэрэгжих үндэслэлийг тодорхойлсон заалт юм. Учир нь эд хөрөнгө барьцаалах асуудал нь Иргэний хуульд зааснаар талуудын чөлөөт хүсэл зоригт үндэслэн үүсдэг тул үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд шаардлагаа хангуулах баталгаа болсон барьцаанд байгаа эд хөрөнгийн өмчлөлийн асуудалд түүний тодорхой ашиг сонирхол хөндөгдөж байдаг.

Өөрөөр хэлбэл, өмчлөгч иргэн буюу зээлдэгч нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс үл маргах журмаар гаргуулахаар харилцан тохиролцсон гэрээг төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэг бүхий нотариатчаар гэрчлүүлсэн байх шаардлагыг хуульчилсан байдаг. Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлд заасны дагуу нотариатч нь үйлчлүүлэгчид эрх, үүргийг нь тайлбарлан, тухайн үйлдлийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхийг тодруулан, эрх зүйн үр дагавар, хууль зүйн ач холбогдлыг тайлбарлаж зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээсээ үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй талаар, мөн хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу нотариатч уг гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ талууд тэгш эрхийн үндсэн дээр гэрээ, хэлцэл байгуулсан эсэх, бусдын дарамт, шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд автсан эсэх, гэрээний агуулга нь талуудын хүсэл зоригийг бүрэн илэрхийлж чадсан эсэх, үүсэх үр дагавар, үр дүнд бодитой хандаж чадсан эсэх, гэрээний агуулга, гарах үр дагавар, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээх хариуцлага



зэргийг бүрэн гүйцэд ойлгосон эсэхийг талуудаас тодруулж, эдгээр нөхцөл байдлын аль нэг нь зөрчигдсөн бол нотариатч гэрээг гэрчлэхээс татгалзах үүрэгтэй, мөн Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.2 дахь хэсэгт “Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.” гэж заасантай нийцүүлэн Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг хуульчилсан.

Дээрх хуулийн зохицуулалт нь өвлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, түүнчлэн өв залгамжлуулах эрхийг хязгаарласан заалт биш юм. Энэ нь үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгүүлэгчийн хооронд гэрээний үндсэн дээр байгуулагдсан барьцаалбарын асуудал хөндөгдсөн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаалагчийн ашиг сонирхолтой холбоотой хэрэглэгдэх зохицуулалт болохоос биш өвлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлах утгаар хэрэглэгдэхгүй болно.

Нотариатын тухай хуульд зааснаар өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох асуудал нь нотариатчийн эрхлэх үйлдлийн нэг төрөл бөгөөд өвлөх эрхийг баталгаажуулах үйлдэл юм. Хуульд зааснаар нотариатчаас гадна өвлөх эрхийн гэрчилгээг нотариатын үүрэг гүйцэтгэгч болох нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хавсран эрхэлж байгаа сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон Монгол Улсын дипломат төлөөлөгч, консулын газар олгож болдог.

Иймд Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийн “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Үндсэн хуулиар иргэдэд олгосон хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг зөрчөөгүй гэсэн тайлбарыг уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Өмчлөх эрх нь өмчлөгчийн язгуур эрх учир иргэний өмчлөх, өв залгамжлуулах эд хөрөнгөд өмчлөгчийн хүсэл зоригийн эсрэг хөндлөнгөөс халдаж болохгүй. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд иргэний өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтаар хуульчлан баталгаажуулсан болно.

2. Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалахаар зааж, эрх зүйн этгээдийн хооронд үүсэх

эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль зэргээр нарийвчлан зохицуулж байна.

Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1, 156.3 дахь хэсэгт зааснаар барьцааны гэрээг бичгээр байгуулах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байхаар зохицуулж, мөн хуулийн 154 дүгээр зүйлийн 154.1, 154.2 дахь хэсэгт зааснаар өмчлөгч өөрийн өмчлөлийн хөрөнгийг хэд хэдэн этгээдэд давхар барьцаалж болох бөгөөд энэ нөхцөлд барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нар нь барьцааны гэрээг байгуулсан дарааллын дагуу өөрсдийн шаардлагаа хангуулах эрхтэй байхаар хуульчилжээ. Мөн уг хуулийн 515 дугаар зүйлийн 515.2 дахь хэсэг, 535 дугаар зүйлд зааснаар өв хүлээн авсан өвлөгчид эсхүл холбогдох журмын дагуу өвийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан өвийн хэмжээгээр хувь тэнцүүлэн хариуцахаар зохицуулсан байна. Үүнээс үзэхэд өвлөгдөх эд хөрөнгө буюу өв барьцаанд байгаа нөхцөлд тухайн өвийг өвлөгч хүлээн авсан, эсхүл татгалзсан, улмаар өвлөх эрхийн гэрчилгээг өвлөгчид олгосон, холбогдох төрийн байгууллага өвийг шилжүүлэн авсан зэргээс үл хамааран барьцаалагч этгээд өөрийн шаардлагаа өвлөгчийн өвлөн авсан өвөөс хангуулах эрхийг хөндөхөөргүй байна.

Гэтэл Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж зааж өвлөгдөх эд хөрөнгө буюу өв нь барьцаанд байгаа нөхцөлд өв хүлээн авагчид өвлөх эрхийн гэрчилгээг олгохдоо тухайн эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрөл авахаар хуульчилсан байна.

Үүнээс үзэхэд Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг нь өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу бусдаас хараат бусаар хэрэгжих өмчлөх, өв залгамжлуулах эрх, нөгөө талаас хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг гэрээслэл болон хуулийн дагуу өв залгамжлах эрхэд хязгаарлалт тогтоосноороо Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.



Түүнчлэн уг зохицуулалт нь иргэний эрх зүйн тэгш эрхийн зарчмыг алдагдуулж, өвлөгдөх эд хөрөнгийг барьцаалсан байгууллагад давуу байдал бий болгосон байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн өмчлөгч өөрийн өмчлөлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг бусдын эзэмшил, өмчлөлд шилжүүлэхдээ үүрэг гүйцэтгүүлэгч, барьцаалагчийн зөвшөөрөл авсан байхыг шаардсан агуулга бүхий зохицуулалтын талаарх маргааныг хянан хэлэлцээд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж 2015 оны 11, 2017 оны 01 дүгээр тогтоолоор уг зохицуулалтыг хүчингүй болгосон байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолын үндэслэх хэсэгт “Ипотекийн зүйлийн өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх, түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалах, барьцаалуулсан газар дээрээ барилга байгууламж барих зэргээр туйлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ингэснээрээ барьцаалагчийн эрхийг зөрчихгүй, барьцаалагчид гэм хор учруулахгүй юм. Учир нь ипотекийн зүйлийн өмчлөл, эзэмшил хэнд шилжсэнээс үл хамааран барьцааны зүйлийг дагалдан ипотекийн эрхээ хэрэгжүүлэх давуу эрх нь барьцаалагчид хэвээр хадгалагддаг. Мөн ипотекийн зүйлийг давхар барьцаалах нь ипотекаар хангагдах шаардлагаа тэргүүн ээлжинд хангуулах өмнөх барьцаалагчийн эрхийг хөнддөггүй. Монгол Улсын Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэж заасан нь өмчлөгчийн туйлын эрхийг баталгаажуулсан үндсэн зохицуулалт юм.” гээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан барьцааны зүйлийг гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх эрхтэй.” гэж заасны “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн хэсэг нь барьцаалагч талд давуу байдал олгосноор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлын зарчим, Үндсэн хуулиар тогтоосон өмчлөгчийн язгуур эрхэд халдсан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн

3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэж, Үндсэн хуулийн цэц 2015 оны 11 дүгээр тогтоолоор дээрх хуулиудын заалтыг хүчингүй болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна.

2. Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийн “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Д.СОЛОНГО
Г.ТУУЛХҮҮ**



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Наранбаяр, Г.Бямбажаргал болон, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Наранбаяр, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Бямбажаргал нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заажээ.

Энэхүү заалтаас үзвэл иргэдийн Төлөөлөгчийг “нэр дэвшигчийн” хувьд гэсэн онол, арга зүйн огт байхгүй ойлголтыг бий болгосон байдаг. Үндсэн хуулийн эрх зүйн хувьд нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомжийн шаардлагын дагуу сонгогдсон нөхцөлд иргэдийн Төлөөлөгч гэсэн субъект болдог. Иргэдийн Төлөөлөгч хэмээх субъект буцаж нэр дэвшигч болох тухай хууль зүйн зохицуулалт байж хэрхэвч болохгүй. Сонгуулийн эрх зүйн хувьд нэр дэвшигчийн талаарх эрх зүйн зохицуулалт, иргэдийн Төлөөлөгчийн талаарх эрх зүйн зохицуулалт тус тусдаа байх ёстой. Энэхүү нөхцөл байдал нь сонгуулийн үр дүнд иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажиж, мандат авсан иргэдийн Төлөөлөгчийн бүрэн эрхэд нэр дэвшигчтэй адил халдах байдлыг үгүйсгэж байгаагаараа түүний Үндсэн хуулийн хүрээн дэх эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.1 дэх хэсэгт сонгуулийн байгууллага нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасахаар зохицуулсан байдаг. Энэ зүйлийн агуулгаас үзвэл иргэдийн Төлөөлөгчийн мандатыг сонгуулийн байгууллага хүчингүй болгож, бүрэн эрхийг дуусгавар болгож байх юм. Гэтэл Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд Сонгуулийн байгууллага нь сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн чиг үүрэг бүхий этгээд юм. Үндсэн хуулийн эрх зүйн агуулгаар бол сонгуулийн харилцаанд нэр дэвшигч ялалт байгуулж ард түмний төлөөлөгчөөр буюу иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож, бүрэн эрх нь баталгаажсан тэрхүү эрх зүйн механизмаар буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эсэх асуудлыг шийдвэрлэж байх ёстой.



Сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт нэг талаасаа сонгогчдын сонгох эрх, иргэдийн Төлөөлөгчдийн сонгогдох эрхэд Үндсэн хуулийн агуулгад нийцээгүй байдлаар халдаж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн хуульчилсан заалтын агуулгатай дээрх зохицуулалт зөрчилдөж байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заажээ. Гэтэл орон нутгийн хурлын сонгуулиас бусад төрлийн сонгуульд энэ заалттай төсөөтэй буюу ижил зохицуулалт байхгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн харилцаанд Улсын Их Хурлын гишүүн болон Ерөнхийлөгчийн тухайд “нэр дэвшигчийнх” нь хувьд гэдэг ойлголт, зохицуулалт байдаггүй. Энэ нөхцөл байдал нь сонгуулийн харилцаанд эрх тэгш байдлыг алдагдуулж байгаа зохицуулалт гэж үзэх үндэслэлийг бий болгож байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.» гэсэн заалттай Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг бүрэн нийцэхгүй байгаа юм.

3. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заажээ. Энэ зүйлийн зохицуулалт нь өнгөцхөн харахад хууль тогтоомжийн зохицуулалтын алдаа мэт харагдах хэдий ч хэрэгжиж байгаа мөн чанар нь ард түмний засгийн эрх мэдэлд халдсан шинжтэй байгаа юм. Бодит амьдрал дээр сонгуулийн байгууллага иргэдийн Төлөөлөгчдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, мандатыг нь хүчингүй болгож байгаа практик байгааг дурдах нь зүйтэй. Цаашид энэхүү байдал үргэлжлэх нь Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлээр тодорхойлогдсон эрхэнд ноцтой халдаж байх нөхцөл бүрдүүлж байгаа билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” хэмээн заасан юм. Сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан зохицуулалт нь агуулгын хувьд Үндсэн хуулийн энэхүү заалттай бүрэн харшилж байна. Учир нь ард түмэн сонгосон төлөөлөгчдийн байгууллагын тухайд түүнийг төлөвшүүлэн бүрдүүлсэн эрх зүйн механизмаар уг байгууллагыг бүрдүүлж буй иргэдийн Төлөөлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах хууль зүйн зохицуулалтыг тодорхойлох ёстой. Гэтэл энэ асуудлыг сонгуулийн байгууллага шийдвэрлэх эрх мэдэлтэй байхаар Сонгуулийн хуулиар хуульчилсан юм. Иймд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн мандатыг хүчингүй болгож, бүрэн эрхийг нь дуусгавар болгох талаарх Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь дээр дурдсан агуулгатай бүрэн нийцэхгүй байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг тус тус зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэснийг зөрчөөгүй талаар:



Монгол Улсын Үндсэн хуулиар засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх зарчмыг хуульчилсан нь төрийн засаглах эрх мэдлийн эх сурвалж нь ард түмэн гэснийг нотолж байгаа хэлбэр бөгөөд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэдэг нь ардчиллын зарчмын хэрэгжилтийг хангах засаглалын оновчтой механизм юм. Иймд төлөөлөх ардчилал нь ард түмний сонгон байгуулсан төрийн байгууллагаараа дамжуулж төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлдэг удирдлагын арга бөгөөд Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын засгийн бүх эрх мэдлийг ард түмний мэдэлд байх зарчмыг зөрчөөгүй ба ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох боломжийг нь ямар нэг байдлаар хөндөөгүй болно.

Үндсэн хуулийн зарим төрлийн эрхэд зөвшөөрөх журам тогтоосон байдаг. Холбогдох төрийн байгууллага эсвэл нутгийн удирдлагын байгууллагаас зөвшөөрөл авсны дараа зөвхөн тэдгээр нь хэрэгжих боломжтой болно. Гэхдээ хүн өөрийн Үндсэн хуулийн эрхийг чөлөөтэй эдэлж болох боловч эрхээ буруугаар ашигласан, хууль зөрчсөн нөхцөлд хариуцлага хүлээлгэх механизм бүрддэг. Сонгуулийн тухай хуульд аливаа сонгуульд нэр дэвшихдээ хориглох үйлдэл болон түүний улмаас нэрийн жагсаалтаас хасах зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан. Тиймээс орон нутгийн төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч тухайн сонгуульд нэр дэвшихдээ хууль зөрчиж төлөөлөгчөөр сонгогдсон бол сонгуулийн хорооны шийдвэрээр тухайн төлөөлөгчийн мандатыг хүчингүй болгож, бүрэн эрх нь дуусгавар болгоно. Учир нь ард түмэн төрийн үйл хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлснээр сонгож байгуулсан орон нутгийн Хурлын төлөөлөгч нь сонгогдохдоо хуульд заасан хориглох хэм хэмжээг зөрчин сонгогдсон нь ард түмний сонгох эрхийг зөрчсөн үйлдэл болох тул орон нутгийн төлөөлөгчийн хувьд шинээр илэрсэн нөхцөл байдлыг нь харгалзан тухайн төлөөлөгчийн мандатыг нь хүчингүй болгож, бүрэн эрхийг нь дуусгавар болгох үндэслэл болно.

Сонгуулийн тухай хуулийн 151 дүгээр зүйлийн 151.1 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын сонгууль нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг орон нутгийн иргэд өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга мөн.” гэж заасан үндэслэлээр сонгогчид төрийн үйл ажиллагаанд шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эрхээ эдэлж байгааг нь зөрчөөгүй бөгөөд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь орон нутгийн хурлын төлөөлөгчийг сонгох журмыг тогтоосон заалт бөгөөд энэ нь ард түмний засаглах бүрэн эрхийг үл хөндсөн болно.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчөөгүй талаар:

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь аливаа этгээдэд адил шударга, хүндэтгэлтэй хандаж, хуулийг чанд, нэг мөр хэрэглэх агуулгыг илэрхийлдэг бөгөөд хуулийн өмнө тэгш байх ерөнхий эрхийн хүрээнд тэгш сонгогдох эрх хамгаалагдсан болохыг илэрхийлдэг. Гэхдээ тодорхой тохиолдолд буюу зөрчил үйлдсэн этгээдэд түүний зан үйлээс шалтгаалан үйлдэл, үйл ажиллагаанд хуулийн нэг зохицуулалт ялгаатай байдлаар бус харин хуулийн өөр зохицуулалт үйлчлэх нь хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг хөндөхгүй байх бөгөөд энэ нь шударга ёсны зарчимд илүү нийцнэ гэж үзэж байна. Үндсэн хууль зөвхөн тэгш эрхийг хангаж, өөрөөр хэлбэл бүх хүнд нэгэн адил хууль зүйн ижил боломж олгодог, ижил тэгш үүрэг хүлээлгэдэг. Тиймээс хуулийн өмнө тэгш байна гэдэг нь албан тушаал, нийгмийн байдал, хувь хүний бусад шинж чанараас үл хамааран хууль бүгдэд нь адил үйлчилж, хууль зөрчсөн нөхцөлд бүх хүн адилхан хариуцлага хүлээх ёстой гэсэн үг юм.

Сонгуулийн тухай хуульд Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, эрх үүрэг, баталгаа, хориглох үйлдэл, үйл ажиллагаа, захиргааны зөрчлийн хэлбэр, хариуцлага зэргийг нийтлэг байдлаар хуульчилсан. Сонгуулийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2 дахь хэсэг, 159 дүгээр зүйлийн 159.2 дахь хэсэгт нэр дэвшигч Сонгуулийн тухай хуулийн 52, 67.3, 70.1, 70.5.1-70.5.10, 70.5.13-70.5.16 дахь заалтад заасан үндэслэл тогтоогдвол уг нэр дэвшигчийг бүртгэсэн сонгуулийн байгууллага нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлэх талаар адил зохицуулалттай. Тиймээс Сонгуулийн тухай хуулийн холбогдох зүйлд нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн хамаарах хэсэгт заасан үндэслэл тогтоогдсон тохиолдолд орон нутгийн Хурлын төлөөлөгчөөр хүлээн зөвшөөрөгдсөн ч нэр дэвшигчийн хувьд нэрийн жагсаалтаас хасаж төлөөлөгчийн мандат хүчингүй болно.

Төрийн үйл ажиллагааны эрх чөлөө, тэгш байдлын зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд сонгуулийн тухай хуулийн үндсэн зорилго болох аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн



Төлөөлөгчдийн Хурлын үндсэн зарчим, журам, сонгууль зохион байгуулахтай холбоотой харилцааг бусад эрх бүхий этгээдийн сонгуультай адил зохицуулсан нь шударга ёсны зарчмыг хангаж байгаа тул төрийн үйл ажиллагаанд эрх чөлөө, тэгш байдлын зарчим зөрчигдөөгүй гэж үзэж байна.

3. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчөөгүй талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэн нь шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан бөгөөд төрийн зохих байгууллага, албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан хуулиар тусгайлан тогтоож болохоор заасны дагуу Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт нэр дэвшигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилжээ.

Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “нэр дэвшигч” гэж энэ хуульд заасан журмын дагуу тухайн сонгуульд нэр дэвшиж бүртгүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг хэлнэ гэж заажээ. Орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн эрх зүйн байдлыг адил тодорхойлсон бөгөөд нэр дэвшигч сонгуулийн тухай хуулийн хориглох заалтыг зөрчиж иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь баталгаажсан ч түүний эрх зүйн байдал нь хэрхэн тодорхойлогдсон байсан нь үл хамааран бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангаж, төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах Үндсэн хуулийн зарчмыг хангаж байна гэж үзсэн болно.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг батлан гаргаж Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон орон нутгийн хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуулийн үеийн зөрчлийн хэлбэр, нэр дэвшигчийн жагсаалтаас хасах үндэслэл зэргийг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2, 159 дүгээр зүйлийн 159.2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчдийг ижил үндэслэлээр нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлэхээр нэгэн адил зохицуулжээ.

Гэтэл тус хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж хуульчилсан боловч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшиж сонгогдсон гишүүн тангараг өргөн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний дараа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл нь тогтоогдвол ямар нэгэн хариуцлага тооцох талаар Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.

Ийнхүү сонгуулийн дүнд байгуулагддаг Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд нь хүлээлгэх хариуцлагыг илтэд ялгавартайгаар, тухайлбал Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшин сонгогдож тангараг өргөн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Улсын Их Хурлын гишүүнд хүлээлгэх энэ төрлийн хариуцлагыг хуульчлаагүй нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан, Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.



2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн мандатыг хүчингүй болгох, бүрэн эрхийг дуусгавар болгох үр дагавар бүхий шийдвэрийг орон нутгийн сонгуулийн хороо гаргахаар хуульчилсан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулиар тодорхойлогдсон эрх хэмжээнд тухайн сонгуулийг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллага халдах боломж олгосон зохицуулалт болжээ.

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсгийн найруулга, хууль зүйн томъёолол боловсронгуй бус, хууль зүйн техникийн хувьд алдаатай, мөн түүнчлэн хуулийн системчлэлийн хувьд уг хуулийн уялдаа холбоо бүхий зүйл, заалтад болон бусад холбогдох хуульд энэ талаарх зохицуулалт, журмыг тодорхой тусгаагүй байна.

3. Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчимд нийцүүлэн сонгуулийн аль ч үе шатанд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон бол тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хэн боловч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байхаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага байгааг хууль тогтоогч анхаарвал зохино.

4. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын Монгол Улсын иргэн “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын Монгол Улсын иргэн “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэсэн заалтын үйлчлэлийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.



4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЧИНБАТ

ГИШҮҮД

**Д.ГАНЗОРИГ
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003